

## УЛААНБААТАР ХОТ

1. Хүн амын суурьшлыг бүсээр ангилж үзэхэд нийт хүн амын 44 хувь нь Улаанбаатар хот, 19 хувь нь хангайн бүс, 17 хувь нь төвийн бүс, 13 хувь нь баруун бүс, 7 хувь нь зүүн бүсэд оршин сууж байна.
2. Монгол улсын нийт хүн амын 44 хувь нь нийслэл хотод байнга оршин сууж байна. Нэг өрх дунджаар 3.7 ам бүлтэй.
3. Улаанбаатар хот хүн ам нягтралаараа Монгол улсад хамгийн өндөр хэвээр байна. Нэг квадрат километр нутаг дэвсгэрт 2000 онд 162 хүн ногдож байснаа 2010 онд 246 болж, 1.5 дахин өсчээ.
4. Улаанбаатар хот Монгол Улсын бүх нутаг дэвсгэрийн дөнгөж 0.3 хувийг эзэлдэг атлаа хүн амын 44 хувь нь оршин сууж, энэ байдал цаашид ч нэмэгдэх хандлагатай байна.
5. Нийслэлд өдөрт 74 хүүхэд мэндэлж, 19 хүн нас барж байна.
6. Нийслэлд өдөрт шинээр 11 хос гэр бүл болж, 4 хос гэр бүлээ албан ёсоор цуцлуулдаг.
7. Нийслэл хотод бусад аймаг, хотоос 109 хүн өдөрт бүрмөсөн шилжин ирж, 40 хүн бусад аймаг, хот руу бүрмөсөн шилждэг.
8. Гадаадын 1527 хүн албан ажил, аялал жуулчлал, бүрмөсөн суурьших зэрэг зорилгоор нийслэл хотод ирж байна.
9. Улаанбаатар хотод сүүлчийн 5 жилд бусад аймгаас 185.5 мянга, сүүлчийн нэг жилийн дотор 61.3 мянган хүн шилжин суурьшжээ.
10. 2000-2010 онд нийслэл, 5 аймгийн хүн амын тоо өсч, бусад бүх аймгийн хүн амын тоо буурчээ.
11. Улаанбаатар хотын хүн амын өсөлт улсын дунджаас бараг 4 дахин өндөр байгаа нь нийслэл рүү чиглэсэн шилжих хөдөлгөөнтэй холбоотой.
12. Нийслэлд оршин сууж байгаа гадаадын харьяат иргэдийн эзлэх хувийн жин өмнөх тооллогын үеийнхтэй ойролцоо байна.
13. 2000 онд нийт гадаадын харьяат иргэдийн 56.2 хувь нь Улаанбаатар хотод амьдарч байсан бол 2010 онд 56.7 хувь байна.
14. Улаанбаатар хотын хүн амын нягтрал 2000-2010 оны хооронд 51.9 хувь, Орхон аймгийнх 28 хувиар тус тус өсчээ.
15. Хүн ам, орон сууцны тооллогын үед Улаанбаатар хотын хүн амын 51.1 хувь бусад бүсээс шилжин ирж суурьшсан байгаа нь хамгийн өндөр, үүний

дараагаар төвийн бүс, харин хүн ам хамгийн бага шилжин ирж суурьшсан бүс нь баруун бүс байна.

16. Улаанбаатар хотын хүн ам 5 жилийн дотор шилжих хөдөлгөөний улмаас 135.7 мянган хүнээр нэмэгдсэн нь тоологдсон хүн амын 11.8 хувийг эзэлж байна.
17. 2005 оны 1 дүгээр сард Улаанбаатарт байнга сууж байсан хүн амын 94.4 хувь нь Улаанбаатар хотод тоологджээ.
18. Улаанбаатар хотын хүн амын өсөлт бусад хотуудаас ихээхэн илүү байгаа төдийгүй 2 тооллогын хооронд 349.2 мянган хүнээр (51.9 хувь) нэмэгдэж, 2010 оны тооллогын дүнгээр улсын нийт хүн амын 44 хувийг эзэлдэг болов.
19. Улаанбаатар хотод төрсөн хүмүүс өөр бүсэд шилжин суурьших сонирхол тун бага байгааг сүүлчийн хоёр тооллогын дүн харуулав. Улаанбаатар хотод төрсөн, тоолох үед нийслэлд байнга оршин сууж байгаа хүн амын эзлэх хувь 92.3 байгаа нь өнгөрсөн тооллогын үеийнхээ төвшинд байна.
20. Улаанбаатар хотын хүн ам 5 жилийн дотор шилжих хөдөлгөөний улмаас 135.7 хүнээр нэмэгдсэн нь тоолох үед байнга оршин сууж байсан хүн амын 11.8 хувийг эзэлж байна.
21. Улаанбаатар хотод 37.4 мянга буюу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн 34.6 хувь нь оршин сууж байна.
22. Нийслэлийн суурин хүн амын 23 хувийг Баянзүрх дүүргийн хүн ам эзэлж байна.
23. Нийслэлийн суурин хүн амын 22 хувийг Сонгинохайрхан дүүргийн хүн ам эзэлж байна.
24. Нийслэлийн суурин хүн амын 16 хувийг Баянгол дүүргийн хүн ам эзэлж байна.
25. Нийслэлийн хүн амын 13 хувийг Чингэлтэй дүүргийн хүн ам эзэлж байна.
26. Нийслэлийн суурин хүн амын 12 хувийг Сүхбаатар дүүргийн хүн ам эзэлж байна.
27. Нийслэлийн хүн амын 10 хувийг Хан-Уул дүүргийн хүн ам эзэлж байна.
28. Багахангай дүүрэгт 3.6 мянган хүн амьдран суудаг бөгөөд энэ нь нийслэлийн суурин хүн амын 0.3 хувийг эзэлж байна.
29. Багануур дүүрэгт нийслэлийн суурин хүн амын 2 хувь нь амьдран суудаг.
30. Налайх дүүрэгт нийслэлийн хүн амын 3 хувь нь амьдран сууж байна.

31. Монгол улсын 338 сум, дүүргээс хүн амын тоогоор Багахангай дүүрэг 226-рт байна.
32. Монгол улсын 338 сум, дүүргээс хүн амын тоогоор Багануур дүүрэг 321-рт байна.
33. Монгол улсын 338 сум, дүүргээс хүн амын тоогоор Налайх дүүрэг 328-рт орж байна.
34. Монгол улсын 225 сум хүн амын тоогоороо Багахангай дүүргээс бага байна.
35. Хүн амын тоогоор нийслэлийн Багахангай дүүрэгтэй ойролцоо буюу хүн ам нь 4000 хүрэхгүй 30 сум бусад аймагт байна.
36. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор нийслэлийн Баянзүрх дүүрэгт 274.6 мянган хүн тоологдсон нь Монгол улсын хамгийн их буюу 114.3 мянган хүн амтай Хөвсгөл аймгаас илүү байна.
37. Хамгийн их хүн амтай Хөвсгөл аймгаас нийслэлийн Баянзүрх дүүрэг 160.3 мянган хүнээр илүү буюу 274.6 мянган хүн амтай.
38. Хамгийн их хүн амтай Хөвсгөл аймгаас Сонгинохайрхан дүүрэг 142.7 мянгаар илүү буюу 257 мянган хүн амтай юм.
39. Хамгийн их хүн амтай Хөвсгөл аймгаас нийслэлийн Баянгол дүүрэг илүү буюу 117.1 мянган хүн амтай.
40. Хамгийн их хүн амтай Хөвсгөл аймгаас Чингэлтэй дүүрэг 31.5 мянгаар илүү буюу 145.8 мянган хүнтэй.
41. Хамгийн их хүн амтай Хөвсгөл аймгаас нийслэлийн Сүхбаатар дүүрэг илүү буюу 125.7 мянган хүнтэй байна.
42. Монгол улсад 2011 онд тоологдсон нийт аж ахуйн нэгжийн 68.6 хувь буюу 45.6 мянга нь нийслэл Улаанбаатар хотод байрлаж байна.
43. Нийслэл хотод өдөрт 24 аж ахуйн нэгж, байгууллага шинээр байгуулагдаж, улсын бүртгэлд бүртгүүлдэг.
44. Нийслэл хотын 27.0 мянган ААНБ байнгын үйл ажиллагаа явуулж, өдөрт 14.3 тэрбум төгрөгийн баялагийг бүтээж байна.
45. Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын 89 гаруй хувь нь 1-9 ажиллагчидтай байна.
46. Улаанбаатар хотод улсын нийт баялгийн 62 гаруй хувь бий болж байна.
47. Монгол улсын эдийн засгийн 62 гаруй хувийг Улаанбаатар хот дангаараа эзэлж байна.

48. Монгол улсын нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 2010 оны үнээр 3.1 сая төгрөг байхад нийслэлийн нэг хүнд ногдох нэмүү 4.6 сая төгрөг болж, өнгөрсөн оноос 1.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
49. Улаанбаатар хотод Монгол улсын барилга угсралт, их засварын ажлын 67 хувь нь хийгдэж байна.
50. Нийслэлийн нэг өдөрт 2.3 тэрбум төгрөгийн жижиглэн худалдаа, 9 тэрбум төгрөгийн бөөний худалдаа хийдэг.
51. Улаанбаатар хотод өдөр бүр 3519 хүнсний дэлгүүр, 81 бөөний худалдааны төв, 22 зах, 791 түргэн үйлчилгээний цэгүүд ажиллаж байна.
52. Хөдөлмөрийн насны 100 хүн бүр 40 хүүхэд, хөдөлмөрийн нас хэтэрсэн 9 хүн тэжээхээр өдөр бүр ажиллаж байна.
53. Нийслэл хотод 2010 оны байдлаар хөдөлмөрийн насны ажил эрхлээгүй 114355 хүн байна.
54. Ажил эрхлээгүй нийт хүн амын 72 гаруй хувь нь 16-40 насны хүн ам байна.
55. Ажилгүй хүмүүсийн 29.7 хувь буюу 34.0 мянга гаруй нь ажил эрхлэх хүсэлгүй болон тодорхой шалтгаангүйгээр хөдөлмөр эрхлээгүй байна.
56. Нийслэлийн ажил эрхлээгүй иргэдийн 34265 нь өдөр бүр ажил идэвхитэй хайж, ажил хийхэд бэлэн байна.
57. Албан ёсны статистикийн 2007 оны "Ажиллах хүчний судалгаа"-гаар нийслэлд ажилгүйдлийн түвшин 22.1 хувь байсан бол жил тутам энэ хувь буурч 2010 оны байдлаар 8.7 хувь болсон.
58. Хөдөлмөрийн бирж, албаар зуучлуулан өдөрт 45 хүн ажилтай болж байна.
59. Нийслэлийн нэг өрх өдөрт 19875 төгрөгийн орлого олж, 20455 төгрөгийг амьжиргаандаа зарцуулдаг.
60. 2011 оны 1-р улирлын байдлаар өрхийн мөнгөн орлогын 56.0 хувийг цалин хөлс, 17.9 хувийг тэтгэвэр, тэтгэмж, 16.2 хувийг арилжаа наймаа, хувийн үйлдвэрлэл үйлчилгээний орлого, 9.9 хувийг бусад орлого бүрдүүлжээ.
61. Нэг хүнд ногдох сарын дундаж мөнгөн орлогын хэмжээ нийслэл хотод бусад бүс нутаг болон улсын дундажтай харьцуулахад өндөр буюу 150507 төгрөг байна.
62. Аль нэг гишүүн нь цалинтай ажил эрхэлдэг өрхийн мөнгөн дундаж орлого 623432 төгрөг байна.

63. Хөдөө аж ахуйн бус үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг өрхийн дундаж орлого 973083 төгрөг болж нэмэгдсэн байна.
64. Хүн амын хэрэглээний тэгш бус байдал нийслэлд улсын дунджаас илүү буюу 0.370 болжээ.
65. Нийслэлийн хүн амын хамгийн чинээлэг хэсгийнхний хэрэглээний дундаж хэмжээ ядуу иргэдийн хэрэглээнээс бараг 6 дахин их байна.
66. Нийслэлийн нийт хүн амын 29.8 хувь нь ядуурлын түвшинд амьдарч байна.
67. Ядуурлын түвшин хэдийгээр улсын дунджаас 10 пунктээр доогуур байгаа ч ядуурал нийслэлд өмнөх жилүүдээс нэмэгдсээр байна.
68. Нийслэлийн 100 хүн тутмын 30 нь зайлшгүй шаардлагатай хүнсний болон хүнсний бус хэрэглээний зүйлийг худалдан авах чадваргүй байна.
69. Нийслэлд орон сууцны 81 мянга гаруй барилга байна.
70. Нийслэлийн орон сууцны нийт барилгын зөвхөн 3.3 хувь нь дэд бүтэцтэй буюу төвлөрсөн халаалт, цэвэр ус, бохир ус татан зайлуулах шугам, цахилгааны сүлжээнд холбогдсон.
71. Нийслэлийн гэр хороололд амьдардаг хүн хоногт 4.9 цэвэр литр хэрэглэдэг.
72. Нийслэлийн инженерийн төвлөрсөн хангамжтай орон сууцанд амьдардаг хүн хоногт 189 литр ус хэрэглэдэг.
73. Нийслэлд хотод 2009 оноос 2011 оны 3-р улирлын хооронд 24440 айлын нийтийн орон сууцны 320 барилга ашиглалтад орсон байна.
74. Монгол улсад бүртгэлтэй нийт автомашины 64 хувь нь нийслэл хотод автомашины техникийн үзлэгт орсон байна.
75. Нийслэл хотын авто замын хөдөлгөөнд өдөрт шинээр 86 автомашин (суудлын 50 автомашин) нэмэгддэг.
76. Шинээр нэмэгдсэн автомашины 10 нь үйлдвэрлэснээс хойш 3 жил хүртэл хугацаагаар ашигласан тээврийн хэрэгсэл байна.
77. Улаанбаатар хотод бүртгэгдсэн нийт тээврийн хэрэгслийн 24 хувийг 4-9 жил, 72 хувийг арав ба түүнээс дээш жилээр ашиглаж байгаа тээврийн хэрэгслүүд тус тус эзэлж байна.
78. Хотын доторхи нийтийн тээврээр өдөрт 613 мянган хүн зорчдог.
79. Нийтийн тээврээр зорчигчдын 40 гаруй хувь нь өдөрт дунджаар 2-оос дээш удаа үнэ төлбөргүй үйлчлүүлж байна.

80. Өдөрт дунджаар 1574 тээврийн хэрэгсэл нийтийн тээврийн үйлчилгээний шугаманд ажиллаж байна.
81. Зогсоолд ирэх автобус хоорондын зай буюу хүлээлтийн дундаж хугацаа их, дунд багтаамжийн 7.4, микро автобусных 5.9 минут, троллейбусных 7.8 минут байна.
82. Нийслэлийн нэг хүнд дунджаар 1.8 ширхэг үүрэн телефон ногдож байна.
83. Нийслэлийн 3 өрх тутмын нэг нь гэртээ компьютертай, компьютертай 2 өрх бүрийн 1 нь өдөр бүр интернет ашигладаг.
84. Нийслэлийн 3 хүн тутмын 1 нь өдөрт дунджаар нэг цаг радио сонсож, 3 өрх тутмын 1 нь кабелийн телевизийн 50 гаруй сувгаар 3 цагийн турш нэвтрүүлэг үзэж байна.
85. Нэг өдөрт 2697 хүн хотын кино театруудад кино үздэг.
86. Нийслэлийн иргэд нэг өдөр 52 мянга гаруй ширхэг сонин, 10136 ширхэг сэтгүүлийг худалдан авч уншдаг.
87. Нийслэлийн нийтийн 28 номын сангаар өдөрт 1172 хүн, үүнээс 222 хүн байнга үйлчлүүлж байна.
88. Нийслэлийн нийтийн номын сангуудаас өдөрт 2.6 мянган ширхэг номыг уншигчдад олгож үйлчилдэг.
89. Өдөрт 574 хүн музей үздэг бөгөөд “Улаанбаатар хотын музей”-г 18 хүн, “Улаанбаатар чуулга”-ын тоглолтыг 1493 үзэгч үзжээ.
90. Нийслэл хотод өдөр бүр 308 спортын заал, танхим ажилладаг.
91. Бүх нийтийг хамарсан аялал, өдөрлөг, чийрэгжилтийн арга хэмжээг жилд дунджаар 50 удаа зохион байгуулж, түүнд 278.1 мянган хүн оролцжээ.
92. Жилд 42.0 мянган тамирчдыг хамруулсан нийслэл хотын аварга шалгаруулах 72 тэмцээн, баяр ёслол, тэмдэглэлт ойн болон нэрэмжит 112 тэмцээн зохион байгуулагдсан байна.
93. Нийслэл хотод Буддын шашны 52 хийд, Христийн 72 сүм, Ислам шашны 1, бусад шашны 4 сүм өдөр бүр ажиллаж байна.
94. Шашны ном сургаалийг 3716 хүүхэд гэрээр, 832 хүүхэд шашны сургууль, дацанд шавилан сууж суралцдаг.
95. Нийслэлийн арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын 61 хувь нь шашин шүтдэг байна.
96. Шашин шүтлэгтэй хүн амын 86.5 хувь нь буддын шашинтан, 6.8 хувь нь бөөгийн шашинтай хүн байна.

97. Өдөрт сургуулийн өмнөх боловсролын 275 цэцэрлэгт 56 мянган хүүхэд хүмүүжиж байна.
98. Нийслэлийн ерөнхий боловсролын 206 сургуульд 185 мянган сурагч сурч байна.
99. Нийслэл хотод мэргэжлийн анхан болон дунд шатны 10 сургуульд 19.0 мянган сурагч, 88 коллеж, дээд сургууль болон 12 их сургуульд 162 гаруй мянган оюутан суралцаж байна.
100. Их дээд сургуулиудын 88.5 хувь нь нийслэл хотод үйл ажиллагаа явуулж байна.
101. Нийслэлийн их, дээд сургууль, коллежийн нийт оюутны 44 хувь нь нийслэлийн, 53 хувь нь бусад аймгийн иргэд байна.
102. 2008 онд улсын нийт оюутны 87 хувь нь Улаанбаатар хотод суралцаж байсан бол 2009 онд 87.5 хувь, 2010 онд 95.3 хувь болж өсчээ.
103. Нийслэлд 6-14 насны 263 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд суралцахгүй завсардсан байна. Эдгээр хүүхдийн 44 гаруй хувь нь амьдрал нь ядуугаас болж сургуульдаа явж чаддаггүй.
104. Эцэг, эхийн хайр халамжаас хөндийрсөн 955 орчим хүүхэд өдөр бүр Улаанбаатар хотын гудамж талбайгаар сэлгүүцэн, орц хонгил, бусад газраар хоноглож байна.
105. Улаанбаатар хотын нэг их эмчид 248 хүн ногдож байгаа нь улсын дунджаас 33 хувиар доогуур байна.
106. Нийт их эмчийн 61 хувь нь нийслэл хотод ажиллаж байна.
107. Нийслэлийн хүн амын дундаж наслалт 68.33 болж, 2004 оноос 3, 2006 оноос 2, 2008 оноос 1 насаар уртассан байна.
108. Нийслэл хотын эмнэлгүүдэд өдөрт 859 хүн хэвтэн эмчлүүлдэг.
109. Халдварт өвчнөөр 48 хүн өдөрт өвчилсний 6 хүн нь вируст гепатитын халдвар авч байна.
110. Нэг өдөрт дунджаар 5 гал түймэр гардаг бөгөөд 2 нь цахилгааны шугамын гэмтлээс шалтгаалдаг.
111. Нэг өдөр авто замын 2 гэмт хэргийг бүртгэн шалгадаг. Нийслэлд жилд дунджаар 100 орчим хүн зам тээврийн ослын улмаас нас баржээ.
112. Нэг өдөрт нийслэл хотод дунджаар 30 гэмт хэрэг гардаг бөгөөд үүний 9 нь хулгайн гэмт хэрэг байна.

113. Гэмт хэргийн улмаас нэг өдөрт дунджаар 2 хүн нас барж, 10 хүн гэмтэж байна.
114. Нийслэлийн худалдаа үйлчилгээний зэрэг хүн олноор цуглардаг газруудад өдөрт дунджаар 14 гэмт хэрэг гардаг.
115. Цагдаагийн ажилтнууд нэг өдөрт дунджаар 6 гэмт хэргийг илрүүлж байна. Өдөрт дунджаар 175 согтуу хүнийг эрүүлжүүлэх арга хэмжээг авдаг.
116. Хот тохижилтын ажилчид өдөрт хотын зам талбайн 9 тн хур хогийг цэвэрлэж, өрхийн 675 тн ахуйн хог хаягдал, гудамж талбайн 24 тн хогийг зөөн зайлуулж, нийт 829 тонн хог хаягдлыг дарж устгадаг.
117. Улаанбаатар хотын хүн ам боловсролын түвшний индекс 0.928 буюу улсын дунджаас дээгүүр байна.
118. Хүний хөгжлөөрөө Улаанбаатар бүс бусад бүс нутаг, улсын дунджаас дээгүүр буюу хүний хөгжлийн индекс 0.790 болжээ.
119. Нийслэлийн хүн амын тоо хамгийн их хүн амтай Хөвсгөл аймгийнхаас даруй 10 дахин их байна.
120. Баянзүрх дүүргийн хүн амын тоо хамгийн их хүн амтай Хөвсгөл аймгийнхаас 2 дахин их байна.
121. Сонгинохайрхан дүүргийн хүн ам Монгол улсын хамгийн их хүн амтай аймаг болох Хөвсгөлийнхөөс 2 дахин их байна.
122. Монгол улсын зүүн бүсийн хүн амын тоо Баянзүрх дүүргийн хүн амын тооноос 75 мянга, харин Сонгинохайрхан дүүргийн хүн амаас 57 мянган хүнээр бага байна.
123. Нийслэлийн төвийн 6 дүүрэгт Монгол улсын хүн амын 39.2 хувь нь амьдран сууж байна.
124. 2011 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаар нийслэлийн 45 хорооны хүн ам 10000-аас их байна.
125. Баянзүрх дүүргийн 21-р хорооны хүн ам 19779 болж, 2011 оны эхний байдлаар нийслэлийн хамгийн их хүн амтай хороо болов.
126. Нийслэлийн хамгийн бага хүн амтай хороо бол Багануур дүүргийн 2-р хороо юм. 2011 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаар тус хороонд 687 хүн амьдран сууж байна.
127. Дундговь аймгийн Цагаандэлгэр сум нь манай улсын хамгийн бага буюу 673 хүн амтай. Харин нийслэлийн хамгийн бага хүн амтай Багануур дүүргийн 2-р хороонд 687 хүн оршин суудаг.
128. Нийслэл хотод хүн ам нь 5000 хүрэхгүй 10 хороо байдаг.

129. Байнга оршин суудаг хүн амын тоо нь 5000 хүрэхгүй 227 сум манай улсад байдаг. Харин нийслэл хотод хүн ам нь 5000 хүрэхгүй 15 хороо байдаг.
130. Монгол улсын 320 сумын 30 нь 10000 мянга хүрэхгүй хүн амтай бол 2010 онд нийслэлийн 45 хорооны хүн ам тус бүртээ 10000-аас дээш болж 2011 онд шинээр 20 хороог байгуулсан.
131. 2007 онд Монгол улсын нийслэлийн нэг сая дахь иргэн, 2011 онд дэлхийн 7.5 тэрбум дахь иргэний чацуутан Улаанбаатар хотод мэндэлсэн.
132. Нийслэл хотод төвлөрөл улам бүр нэмэгдэж байна. 2008 онд төвлөрлийн индекс 61.3 хувь байсан бол 2009 онд 62.5, харин 2010 онд 63.2 хувь болж нэмэгджээ.
133. Монгол улсын хүн амын 44 хувь, иргэдийн хадгаламжийн 83 хувь, нийт олгогдсон зээлийн 80 хувь, барилга угсралтын ажлын 67 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний 63 хувь, оюутны 95 хувь, их дээд сургуулийн 89 хувь, худалдаа үйлчилгээний 51 хувь, нийт аж ахуйн нэгжийн 66 хувь, их эмчийн 61 хувь, автомашины 64 хувь нь нийслэл Улаанбаатар хотод байна.
134. Нийслэлийн нэг иргэн сард хүнсэндээ 6.4 кг мах, 5.8 литр сүү, 11 кг гурил, гурилан бүтээгдэхүүн, 1.7 кг будаа, 4.2 кг төмс, 2.6 кг хүнсний ногоо, 5 ширхэг өндөг хэрэглэдэг.
135. Нийслэл хотын нийтийн эзэмшлийн зам талбайн 3.6 км<sup>2</sup> нь зүлэгжүүлсэн талбай байдаг.
136. Нийслэл хотод жил бүр 1800 га талбайг шинээр зүлэгжүүлж, харин 1700 га талбайг нөхөн зүлэгжүүлдэг.
137. Дэлхийд нэг км кв талбайд хамгийн олон хүн оршин суудаг улсаар Макао тэргүүлж (27000), дараа нь Монако (18125), Хонг Конг (5442), Сингапур (4419), Ватикан Сити (2500), Бермуда (1074), Бангладеш (786), Бахрайн (762), Малдивес (732), Барбадос (598) ордог. Харин нийслэл Улаанбаатар хотын Баянгол дүүргийн хүн амын нягтрал 2011 оны 11-р сарын 1-ний байдлаар 6395 болжээ.
138. Нийслэлийн хүн амын нягтрал багатай дүүргээр Багахангай дүүрэг тэргүүлдэг. Тус дүүргийн нэг км<sup>2</sup> нутаг дэвсгэрт 26 хүн ногддог бол Багануур дүүрэгт 44, Налайх дүүрэг 47 хүн ногдож байна.
139. Нийслэлийн нийт тээврийн хэрэгслийн 72.9 хувийг зөвхөн суудлын автомашин эзэлж байна.
140. Нийслэлийн арван автомашин тутмын долоо нь суудлын автомашин байна.
141. Суудлын автомашины 85.7 хувь нь иргэд, хувь хүмүүсийн эзэмшилд бүртгэлтэй байдаг.

142. Нийслэлийн авто замын хөдөлгөөнд идэвхтэй оролцож буй нийт автобусны 87.6 хувийг бага оврын автобус эзэлж байна.
143. Нийслэлийн авто замын хөдөлгөөнд идэвхтэй оролцож буй нийт автобусны 3.5 хувийг дунд оврын буюу 8 метр болон түүнээс бага урттай автобус эзэлдэг.
144. Нийслэлийн нийт тээврийн хэрэгслийн 20.0 хувь нь аж ахуй нэгж, байгууллагын эзэмшилд бүртгэлтэй байна.
145. Нийслэлийн нийт тээврийн хэрэгслийн 1.6 хувийг төрийн болон орон нутгийн өмчийн, 0.3 хувийг дипломат болон олон улсын байгууллагын, 1.2 хувийг төрийн бус байгууллагын, 16.9 хувийг компани, хоршоо, нөхөрлөлийн автомашин тус тус эзэлж байна.
146. Иргэний хувийн өмчийн автомашин нийслэлийн нийт тээврийн хэрэгслийн дийлэнх буюу 80.0 хувийг эзэлж байна.
147. Иргэний хувийн өмчийн автомашины 62.5 хувь нь суудлын, 13.4 хувь нь ачааны, 3.8 хувь нь автобус, 0.3 хувь нь тусгай зориулалтын автомашин байна.
148. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан 162.7 мянган 66.8 хувь нь "бензин хөдөлгүүр"-тэй автомашин байна.
149. Нийслэлийн нийт автомашины 88.2 хувь буюу 143.5 мянган тээврийн хэрэгсэл нь Япон, БНСУ-д үйлдвэрлэсэн автомашин байна.
150. Нийслэлийн нийт автомашины 9.8 хувийг ОХУ (7.0 мян), Хятад (5.7 мян), Герман (3.3 мян) улсын автомашины марк эзэлж байна.
151. Техникийн хяналтын үзлэгт хамрагдсан нийт автомашины 0.9 хувийг эзэлж буй 1491 тээврийн хэрэгслийн марк үүсгэсэн улс нь АНУ байна.
152. Монгол улсад үүрэн телефон эзэмшиж байгаа нийт хэрэглэгчдийн 83.0 хувь буюу 2102.8 мянган хэрэглэгч нь нийслэл хотод байна.
153. Үүрэн холбоо эзэмшиж буй нийслэлийн иргэдийн 251.0 мянга нь дараа төлбөрт үйлчилгээний, 1851.8 мянга нь урьдчилсан төлбөрт үйлчилгээний хэрэглэгчид байна.
154. Түүнчлэн нийслэлд 41.5 мянга орчим хэрэглэгч утасгүй суурин телефон буюу WLL үйлчилгээг, 0.8 мянган хүн сансарын холбоог эзэмшиж байна.
155. Үүрэн телефон хэрэглэгчдийн тоон үзүүлэлтээр улсын дүнд нийслэл хотын эзлэх хувь хэмжээ 2004-2008 онуудад 75.4-79.1 хувь байсан бол 2009 онд 81.4 хувь, 2010 онд 83.0 хувь болж нэмэгджээ.

156. Монголын Хэвлэлийн Хүрээлэнгийн хэрэглэгчдийн судалгаагаар нийслэлчүүдийн 92 хувь нь өдөр бүр телевиз үзэж, удаад нь интернэт ашиглаж байгаа бол дөрвөн хүн тумын нэг нь радио сонсдог байна.
157. Нийслэл хотод 2 радио (Хамаг Монгол FM95.1, Элгэн нутаг FM96.9) шинээр нэмэгдсэнээр орон даяар нэвтрүүлгээ хүргэдэг Монголын Үндэсний Олон нийтийн радиогоос гадна Улаанбаатар хотын хэмжээнд нэвтрүүлгээ цацдаг 26 радио үйл ажиллагаа явуулж байна.
158. Нийслэлд цацдаг радио нэвтрүүлгийн 92.6 хувь нь хэт богино долгионы радио байна.
159. Нийслэлд цацдаг радио нэвтрүүлгийн талаас илүү хувь нь 24 цагийн турш үргэлжиж, цэнгээнт болон танин мэдэхүй, дуу хөгжим, мэдээллийн хөтөлбөрөө нийслэлийн сонсогчдод хүргэж байна.
160. Нэвтрүүлгээ Улаанбаатар хотын хэмжээнд цацдаг радиогийн 18 нь хувийн, 30.8 хувь нь төрийн бус байгууллагын харьяалалд болон олон нийтийн статустай бөгөөд 7 хоногийн нэвтрүүлгийн цаг нь нийтдээ 3500 гаруйд хүрчээ.
161. Нийслэлд нэвтрүүлгээ сансарын антены тусламжтайгаар үндэсний хэмжээнд цацагддаг телевизийн тоо 14 болж нэмэгджээ.
162. Улаанбаатар хотод нэвтрүүлгээ цацаж буй телевизүүдийн дөрөв нь 2 сувагтай, нэг нь 3 сувагтай үйл ажиллагаа явуулж байна. Эдгээрээс гурав нь Багануур, Налайх дүүрэгт, хоёр нь нийслэлд төдийгүй Дархан, Эрдэнэт хотод нэвтрүүлгээ хүргэж байна.
163. Бие даан нэвтрүүлэг бэлтгэн кабелийн сувгаар цацдаг 7 суваг нийслэлийн хэмжээнд ажиллаж байгаа бөгөөд эдгээрийн 3 нь (Dream, Mongolian Top Music, Moncinema) 2010 онд шинээр байгуулагдаж, сувгийн тоо нийтдээ 40 болов.
164. Үүрэн холбооны оператор Скайтель, Мобисом компанийн хэрэглэгчид гар утсаараа нэвтрүүлгийг нь хүлээн авах боломжтой телевиз 2009 онд дөрөв байсан бол энэ тоо 2010 онд тав (TV9, MN25, C1, МҮОНТ, NTV) болж нэгээр нэмэгдэв.
165. 2010 онд нийслэлийн нийт өрхийн 97.4 хувь буюу 286.6 мянган өрх телевизортой байсан бөгөөд эдгээр өрхийн 88.0 хувь нь нэг телевизортой ажээ.
166. Телевизортой гурван өрх тутмын нэг нь сууцны тусдаа байшинд, 40.2 хувь нь нийтийн зориулалттай орон сууцанд, 26.0 хувь буюу 74.4 мянган өрх нь монгол гэрт амьдарч байв.
167. Нийслэлийн Хан-Уул, Баянгол дүүргийн нийт өрхийн 99.5-99.6 хувь нь, Чингэлтэй дүүргийн нийт өрхийн 99.2%, Сүхбаатар дүүргийн нийт өрхийн

97.1%, Сонгинохайрхан дүүргийн нийт өрхийн 97.0%, Баянзүрх дүүргийн нийт өрхийн 94.1% нь гэртээ телевизортой байна.

168. Монгол Улсын хэмжээнд кабелийн телевизийн сувагт холбогдсон нийт хэрэглэгчдийн ихэнх буюу 79.0 хувь нь нийслэл хотод байна.
169. Кабелийн телевизийн хэрэглэгчдийн тоо жил ирэх тутамд өсөн нэмэгдэж байгаа хэдий ч улсын дүнд нийслэл хотын эзлэх хувь 2010 онд өмнөх оныхоос 0.6 пунктээр буурсан байна.
170. 2010 онд нийслэлийн хэмжээнд кабелийн 11 телевизээр 95.2 мянга гаруй хэрэглэгч үйлчлүүлсэний 94.2 хувь нь айл өрх байна.
171. Тогтмол үйл ажиллагаа явуулсан кабелийн телевизийн үйлчилгээ эрхлэгчдээс 9 нь хотын төвийн дүүргүүдэд үйл ажиллагаа явуулж, үзэгчдэд 48-70 хүртэл (хотын захын дүүрэгт 25-49) сувгаар нэвтрүүлэг дамжуулж цацжээ.
172. Кабелийн телевизийн айл өрхөд үзүүлсэн үйлчилгээний сарын хураамж 3000-5500 төгрөг байв.
173. Нийслэлд интернэтийн үйлчилгээ (Internet service provider) эрхлэх тусгай зөвшөөрлийг 55 аж ахуйн нэгж, байгууллага эзэмшиж байгаагийн 38 нь тогтмол үйл ажиллагаа явуулж, интернэтийн "байнгын хэрэглэгч"-ийн тоо 2010 онд 162.5 мянга болжээ.
174. Улсын хэмжээнд байгаа интернэтийн байнгын хэрэглэгчдийн 81.3 хувь нь нийслэлд байна.
175. Нийслэлийн нийт өрхийн 31.7 хувь нь буюу 93.4 мянган өрх гэртээ компьютертэй болсон байна.
176. Гэртээ компьютертай өрхийн 64.7 хувь буюу 60.5 мянга шахам нь нийтийн зориулалттай орон сууцанд, 10.4 хувь буюу 9.7 мянган өрх монгол гэрт амьдардаг байна.
177. Гэртээ компьютертэй нийт өрхийн 39.5 хувь буюу 36.9 мянга гаруй өрх интернэтэд холбогджээ.
178. Интенэтэд холбогдсон нийт өрхийн 88.9 хувийг нийтийн зориулалттай орон сууцанд амьдардаг өрх эзэлж байна.
179. Нийслэлд борлуулж буй нийт сонины 73 хувийг өдөр тутмын сонин эзэлж байна.
180. 2010 онд нийслэлд өдөр тутмын 15 сонин тогтмол гарч орон даяар түгээгдсэн бөгөөд энэ тоо сүүлийн гурван жилийн турш өөрчлөгдөөгүй байна.

181. Нийслэлд борлуулж нийт сонины 32.7 хувь нь 10-14 хоног тутмын, 21.8 хувь нь сар тутмын, 18.8 хувь нь 7 хоног тутмын, 4.0 хувийг 3-4 хоног тутмын сонин эзэлж байгаа юм.
182. Нийслэлд 2000 онд 37 сэтгүүл 210.0 гаруй мянган хувиар борлогдож байсан бол 2010 онд 100 гаруй нэр төрлийн сэтгүүл нийслэлд үйл ажиллагаа явуулж, борлуулалт нь 3.7 сая гаруй хувьд хүрсэн байна.
183. Нийслэл иргэдийн 38 хувь нь долоо хоног бүр ямар нэг сэтгүүлийг худалдан авч байна.
184. Нийслэлд долоо хоног тутам болон 10-14 хоног тутамд гардаг сэтгүүл 2 дахин нэмэгджээ.
185. Нийслэлд борлуулж буй нийт сэтгүүлд улирал тутмын давтамжтай сэтгүүлийн тоо давамгайлж, 44.6 хувийг эзлэх болсон байна.
186. Нийслэл хотод 3.2 сая ширхэг номын фондтой, нийт 1672 суудал бүхий уншлагын танхимтай 28 нийтийн номын сан ажиллаж байна.
187. Нийтийн номын сангууд 2010 онд нийтдээ 427.8 мянга гаруй хүнд 954.6 мянган ширхэг ном олгож үйлчилжээ.
188. Номын сангуудаас үйлчилсэн нийт номын 91.0 хувийг нь уншлагын танхимд, 7.2 хувийг гэрээр, 1.8 хувийг зөөврөөр олгожээ.
189. Номын сангийн байнгын уншигчдын тоо 2010 онд 81.1 мянга орчим болжээ.
190. 2010 онд нийслэлийн номын сангууд шинээр 45.6 мянган ном авч фондын баяжилт хийсэн бол 80.7 мянган ном фондоос хасагдсан байна.
191. Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй 14 музейд дэлгэн тавьсан нийт үзмэрийн тоо 135.7 мянгад хүрч, 209.6 мянган үзэгчдийн хүртээл болсон байна.
192. Нийслэлийн Налайх дүүрэгт 210 үзмэртэй орон нутаг судлах танхим 1.9 мянган хүнд үйлчилсэн байна.
193. Үзмэрийн тоогоор Монголын Үндэсний музей тэргүүлсэн хэвээр байна. 2010 онд тус музейд шинээр 998 үзмэр нэмэгдэж 50.4 мянган үзмэртэй болжээ.
194. Нийслэлд байрлалтай музейн үзмэрүүд нийтдээ 7.2 тэрбум төгрөгөөр үнэлэгдэх бөгөөд нийт үзмэрийн 63.6 хувь нь Дүрслэх урлагын музей, Богд хааны ордон музей болон Чойжин ламын сүм музейд харъяалагддаг.
195. Нийслэлд музейн үзэгчдийн 74.6 хувь нь Байгалийн түүхийн болон Үндэсний түүхийн, Богд хааны ордон музей, Дүрслэх урлагын музейг үзэж сонирхжээ.

196. Музей үзэгчдийн 40.3 хувийг Байгалийн түүхийн музейд зочилсон үзэгчид эзэлж байна.
197. Музейн үзэгчдийн 57.1 мянга нь хүүхдүүд байгаагаас 49.1 хувь нь буюу 28.0 мянга гаруй хүүхэд Байгалийн болон Үндэсний түүхийн музейг үзсэн байна.
198. Манай оронд 2010 онд зочилсон гадаадын 75.1 мянган жуулчид нийслэлийн музейнүүдийг үзэж сонирхсон нь нийт үзэгчдийн 35.9 хувийг эзэлж, өмнөх оныхоос музей үзсэн гадаад зочдын тоо 20.5 мянгаар нэмэгджээ.
199. 2010 онд нийслэл хотод 2284 суудал бүхий 3 кино театр үйл ажиллагаа явуулж, нийтдээ 12515 удаагийн кино гаргалтаар 984.6 мянган үзэгчдэд үйлчилж, 4.6 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан бөгөөд нийт орлогынх нь 60.0 шахам хувийг үзвэрийн орлого бүрдүүлсэн байна.
200. Кино үзэгчдийн 75.9 хувь нь Тэнгис кино театраар үйлчлүүлжээ.
201. 2010 онд 18.2 мянган суудал бүхий 14 соёлын төв нийслэлийн иргэд, оршин суугчдад жилийн турш үйлчилж, тэдгээрт 2305 арга хэмжээ зохион байгуулагдсан байна.
202. Мэргэжлийн урлагын 12 байгууллагаас 2010 онд нийт 2026 удаагийн тоглолт хийж, 915.0 мянган үзэгчдэд хүргэжээ.
203. Мэргэжлийн урлагын байгууллагуудын 2010 оны нийт тоглолтын 12.6 хувийг хүүхдэд зориулсан тоглолт эзэлж, 93.4 мянган хүүхэд багачууд үзжээ.
204. Хүүхдэд зориулсан 2010 оны нийт тоглолтын 56.9 хувийг Улсын Хүүхэлдэйн Театр зохион байгуулсан байна.
205. Нийслэлийн 17.4 мянган хүүхэд 2010 онд Үндэсний Дуу Бүжгийн Эрдмийн Театрт зочилж тоглолт үзсэн байна.
206. 2010 онд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулсан албан ёсны зөвшөөрөл бүхий нийт сүм хийдийн 55.1 хувь, үүний дотор буддын дацан хийдийн 40.9 хувь, христийн сүмийн 75.0 хувь, исламын болон бусад шашны 45.5 хувь нь нийслэл хотод байршиж байна.
207. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулах албан ёсны зөвшөөрөл, бүртгэлтэй шашны байгууллагуудын 55.8 хувийг христийн сүмүүд эзэлж байна.
208. Нийслэлд буй Христийн сүмийн 46.3 хувь нь протестант, 28.4 хувь нь эвангел урсгалыг, үлдэх хэсэг нь методист, пентикост, баптист, адвентист, католик, үнэн алдартан, морман гэх мэт христийн бусад урсгал чиглэлүүдийг төлөөлдөг.

209. Нийслэлийн арван тав, түүнээс дээш насны 871.8 мянган хүний 61.4 хувь буюу 535.4 мянган хүн шашин шүтдэг байна.
210. Шашинтангуудын тоог шүтдэг шашных нь төрлөөр авч үзэхэд 93.3 хувь нь монголын уламжлалт бурханы болон бөө мөргөлийн шүтлэгтэй байна.
211. Тухайлбал, арван тав, түүнээс дээш насны нийт хүн амын 53.1 хувь, шашин шүтлэгтэй хүн амын дийлэнх буюу 86.5 хувь нь буддын шашинтан ажээ.
212. Бөөгийн шашинтай хүн амын тоо 36.4 мянгад хүрсэн нь шашин шүтлэгтэй хүн амын 6.8 хувийг эзлэх болсон байна.
213. Нийслэлийн 26.5 мянган иргэн христын шашинтан байгаа нь 15, түүнээс дээш насны нийт хүн амын 3.0 хувь, шашин шүтлэгтэй хүн амын 5.0 хувийг эзэлж байна.
214. Нийслэлийн 3.5 мянган иргэн бахай шүтлэг, мүүний гэх мэт бусад шашин шүтдэг ажээ.
215. Шашинтангуудын дотор эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү олон байна. Арван тав, түүнээс дээш насны эрэгтэй хүн амын 56.9 хувь, эмэгтэйчүүдийн 65.5 хувь нь шашин шүтдэг байна.
216. Шашинтангуудын 42.2 хувийг 15-30 хүртэлх насны залуучууд эзэлж байгаа юм.
217. Нийслэлийн суурин хүн амын 18.3% хувийг эзэлж буй 20-24 насны залуучуудын 57.6 хувь, түүний дотор 20-24 насны эрэгтэйчүүдийн 54.5 хувь, эмэгтэйчүүдийн 60.6 хувь нь шашинтан байна.
218. Нийслэлийн 15-19 насны хүүхэд залуучуудын талаас илүү буюу 52.7 хувь нь шашин шүтлэгтэй байхад 35-39 насныхны 63.1 хувь, 45-49 насны хүн амын 64.7 хувь, 55-59 насныхны 68.3 хувь, 60-аас дээш насны хүн амын 71.1-90.6 хувь нь шашин шүтдэгтэй байна.
219. Шашин шүтдэг 15-19 насныхны 7.0 хувь, 20-29 насны залуучуудын 5.4 хувь нь христийн шашинтан байхад 60-69 насанд 3.6 хувь, 70 ба түүнээс дээш насанд 2.7 хувь болж эзлэх хувийн жин буурч байна.
220. Нийслэл хотод 2010 онд 308 спортын заал, танхим жилийн турш ажилласан байна.
221. 2010 онд бүх нийтийг хамарсан аялал, өдөрлөг, чийрэгжилтийн арга хэмжээг 50 удаа зохион байгуулж, түүнд 278.1 мянган хүн оролцжээ.
222. Мөн 42.0 мянган тамирчдыг хамруулсан нийслэл хотын аварга шалгаруулах 72 тэмцээн, баяр ёслол, тэмдэглэлт ойн болон нэрэмжит 112 тэмцээн зохион байгуулагдсан байна.

223. Монгол Улсын ерөнхий боловсролыг 2010-2011 оны хичээлийн жилээс эхлэн 12 жилийн тогтолцоонд шилжүүлсэнээс хойш сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын шинэ стандартаар 4 дахь жилдээ хичээллэж байна.
224. 2010-2011 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт 240.8 мянган хүүхэд, залуучууд суралцаж байна. Өмнөх хичээлийн жилээс сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн тоо 7.5 мянгаар, ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын тоо 0.2 мянгаар өсчээ.
225. 2010-2011 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт 20.4 мянган багш, сурган хүмүүжүүлэгч, ажилчид ажиллаж байна.
226. 2010-2011 оны хичээлийн жилд нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 275 хүүхдийн цэцэрлэгийн 174 нь төрийн өмчийн, 101 нь хувийн өмчийн цэцэрлэгүүд байна.
227. Нийслэлийн цэцэрлэгүүдийн үндсэн бүлэгт 52.0 мянган хүүхэд, хувилбар сургалтад 4.2 мянган хүүхэд, нийт 56.2 мянган хүүхэд багачууд сурч хүмүүжиж байгаа бөгөөд 5.5 хувь буюу 3.0 мянга нь 2 хүртлэх настай хүүхэд байна.
228. Нийслэлийн хэмжээгээр 2-5 насны цэцэрлэгт хамрагдвал зохих нийт хүүхдийн 69.8 хувь нь сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байна.
229. Хувийн өмчийн цэцэрлэгүүдэд нийт 7794 хүүхэд сурч хүмүүжиж байгаа нь өмнөх оны хичээлийн жилтэй харьцуулахад 1214 хүүхдээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.
230. Сургуулийн өмнөх боловсролын салбарт ажиллаж буй үндсэн багшийн тоо 1.8 мянгад хүрч, цэцэрлэгийн нэг багшид дунджаар 30.6 хүүхэд ногдож байна.
231. Улсын дундажтай харьцуулахад нийслэлийн цэцэрлэгийн нэг багшид ногдох хүүхдийн тоо дунджаар 4 хүүхдээр олон байна.
232. 2010-2011 оны хичээлийн жилд нийслэлд ерөнхий боловсролын 206 сургууль үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд төрийн бус өмчийн сургуулийн тоо 96 буюу нийт сургуулийн 46.6 хувийг эзэлж байна.
233. Нийт ЕБС-иудын 66.0 хувь нь нийслэлийн Сүхбаатар, Баянгол, Баянзүрх дүүргүүдэд төвлөрч байна.
234. Төрийн бус өмчийн сургуулийн тоогоор Сүхбаатар, Баянгол дүүргүүд бусад дүүргүүдээс олон байгаа ба хувийн сургуулиудын 58.3 хувь нь тус 2 дүүргийн нутаг дэвсгэрт байршин сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

235. 2010-2011 оны хичээлийн жилд ЕБС-д суралцдаггүй 6-14 насны 263 хүүхэд бүртгэгдсэн бөгөөд тэдний 111 нь эмэгтэй хүүхэд, 53.6 хувь нь сургуульд ороод завсардсан хүүхдүүд байна.
236. ЕБС-д суралцдаггүй нийт хүүхдүүдийн 142 нь 6-11 насныхан , 121 нь 12-14 насныхан байгаа бөгөөд 44.1 хувь нь амьдралын гачаалын улмаас сургууль завсардсан байхад 8.4 хувийнх нь шалтгаан тодорхойгүй ажээ.
237. Улсын дундажтай харьцуулахад анхан шатны боловсролын хүртээмж Улаанбаатар хотод өндөр байна. БСШУЯ-наас гаргасан албан ёсны мэдээгээр нийслэлийн хэмжээнд 1-5-р ангид 96582 хүүхэд суралцаж байгаа бөгөөд 2010-2011 оны хичээлийн жилд 1-р ангид 17398 хүүхэд шинээр элсэн орсон байна. Өмнөх хичээлийн жилээс 1372 буюу 7.9 хувь, 2008-2009 оны хичээлийн жилийнхээс 4581 буюу 26.3 хувь, 2007-2008 оны хичээлийн жилийнхээс 2827 буюу 16.2 хувиар буурчээ. Насны хувьд 85.1 хувийг 6 настай хүүхэд, 8.9 хувийг 7 настай хүүхэд эзэлж байна.
238. Өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад 1-р ангид шинээр элсэгчдийн тоо 7.9хувиар буурч, нийт элсэгчдийн 49.1 хувь нь эмэгтэй хүүхэд байв.
239. Манай улсын ЕБС-иудад 2010-2011 оны хичээлийн жилд 26.4 мянга гаруй багш ажиллаж байгаагаас 9.3 мянга гаруй нь нийслэлийн ЕБС-иудад ажиллаж байна.
240. Нийт бүх ЕБС-иудад 512.2 мянган хүүхэд суралцаж байгаагаас нийслэлийн ЕБС-иудад 184.6 мянган хүүхэд суралцжээ.
241. Төрийн бус өмчийн сургуульд нийтдээ 19.1 мянган хүүхэд суралцсан нь өмнөх хичээлийн жилээс 0.5 хувиар өсчээ.
242. Нийслэлийн ЕБС-ийн нийт суралцагчдын 92.4 мянга буюу 50.1 хувийг эмэгтэй хүүхэд эзэлж байна.
243. ЕБС-ийн нийт суралцагчдаас 96.6 мянган хүүхэд I-V, 59.7 мянга нь VI-IX, 28.3 мянган хүүхэд ахлах буюу X-XII ангид суралцжээ.
244. 2010-2011 оны хичээлийн жилд нийслэлийн ЕБС-ийн нэг багшид ногдох сурагчдын тоо 19.9болж 2009-2010 оны хичээлийн жилийнхээс 0.3-аар буурсан эерэг үзүүлэлттэй байна.
245. 2010-2011 оны хичээлийн жилд нийслэлийн нутаг дэвсгэрт 110 их дээд сургууль, коллеж үйл ажиллагаа явуулснаас төрийн өмчийн 15, төрийн бус өмчийн 91, гадаадын салбар сургууль 4 байв.
246. Нийслэлд шаталсан сургалт явуулдаг Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн 10 төв үйл ажиллагаа явуулж, тэдгээрт 19.0 мянган оюутан суралцсан байна.

247. 2010-2011 оны хичээлийн жилд нийслэлд 12 их сургууль, 88 дээд сургууль, коллеж үйл ажиллагаа явуулсан бөгөөд тэдгээрийн 93.2 хувь нь төрийн бус өмчийн сургуулиуд байна.
248. Дээд боловсрол олгох үйл ажиллагаа явуулж буй нийт их сургуулийн 66.7 хувийг төрийн өмчийн сургуулиуд эзэлж байна.
249. 2010 онд дээд боловсрол олгох сургуулиудад нийтдээ 181.1 мянган оюутан суралцсан бөгөөд 57.1 хувь нь эмэгтэй оюутнууд байв.
250. Нийт суралцагчдын 53.7 хувь буюу 107.4 мянган оюутан төрийн өмчийн 15 сургуульд суралцсанаас 53.3 хувийг их сургуульд суралцагчид эзэлжээ.
251. Нийслэлд төрийн бус өмчийн 91 сургуульд нийтдээ 73.3 мянган оюутан суралцсаны 45.5 мянга буюу 62.0 хувь нь эмэгтэй оюутнууд байв.
252. Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй гадаадын салбар сургуулиудад 0.3 мянган оюутан суралцсан байна.
253. 2010-2011оны хичээлийн жилд өмчийн бүх хэлбэрийн их дээд сургууль, коллежийн дипломын дээд болон бакалаврын өдрийн ангид нийтдээ 143.9 мянга гаруй оюутан суралцсан байна.
254. Өдрийн ангид суралцагчдын 107.4 мянга орчим нь төрийн өмчийн, 73.4 мянга нь төрийн бус өмчийн сургуульд суралцсан байна.
255. Гадаадын салбар сургуульд суралцагчдын хувьд 98.9хувь нь өдрийн ангид суралцжээ.
256. Төрийн өмчийн сургуулийн өдрийн ангид суралцагчдын 53.7 хувь, төрийн бус өмчийн сургуульд суралцагчдын 61.8 хувийг эмэгтэй оюутнууд эзэлсэн байна.
257. 2010-2011 оны хичээлийн жилд дээд боловсрол олгох сургуульд суралцагчдын тоог өмнөх хичээлийн жилтэй харьцуулж үзэхэд бакалаврын ангид суралцагчдын тоо 10.9хувь, магистрантурт суралцагчид 12.8 хувиар, докторантурт суралцагчид 12.7 хувиар нэмэгдсэн байна.
258. Түүнчлэн энэ хичээлийн жилд өдрөөр суралцагчдын тоо нийт суралцагчдын 88.9 хувийг эзэлж байна.
259. Нийслэлийн их, дээд сургууль, коллежид суралцаж байгаа оюутан сурагчдын 44.3 хувь буюу 71.8 мянган оюутан нийслэлийн харьяалалтай, 53.0 хувь буюу 90.3 мянган оюутан хөдөө орон нутгийн харьяалалтай байна.
260. Нийслэлийн аж үйлдвэрийн газрууд 2010 онд оны үнээр 1914.5 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 2187.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь 2009 онтой харьцуулбал үйлдвэрлэлт 47.4 хувиар, борлуулалт нь 57.9 хувиар тус тус өссөн байна.

261. Нийслэлийн аж үйлдвэрийн нийт борлуулалтын 950.2 тэрбум төгрөгийг дотоодод, 1237.1 тэрбум төгрөгийг гадаадад борлуулсан байна.
262. Манай улсын аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалтын 48.9 хувийг нийслэлийн аж үйлдвэрийн салбарын борлуулалт эзэлж байна.
263. Нийслэлийн аж үйлдвэрийн салбарын 54.5 хувийг уул, уурхайн салбарт үйлдвэрлэж байна.
264. Уул уурхайн олборлох салбарын гол нэрийн бүтээгдэхүүний нэг болох нүүрс 2010 онд 12909.7 мянган тонныг олборлосон нь өмнөх оны мөн үеэс 99.7 хувиар өссөн байна.
265. 2010 онд улсын хэмжээнд 100 гаруй аж ахуйн нэгж байгууллага нийт 6037.1 кг алт олборлосны 80.0 хувь буюу 4830.9 кг алтыг нийслэлд бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллагууд олборлосон байна. Олборлосон алтны хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 35.1 хувиар буурсан байна.
266. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлтэд боловсруулах салбарын бүтээгдэхүүн оны үнээр 2005 онд 36.5 хувь, 2006 онд 34.7 хувь, 2007 онд 39.3 хувь, 2008 онд 43.7, 2009 онд 45.0 хувь, 2010 онд 35.5 хувийг эзэлж байгаа нь 2009 оныхоос 9.5 пунктээр буурчээ.
267. Боловсруулах аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлт 2009 оныхоос 20.4 хувиар өсөхөд хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, тамхи үйлдвэрлэл, цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, мод, модон эдлэл үйлдвэрлэл, хэвлэх болон нийтлэх үйл ажиллагаа, төмөрлөг бус эдлэлийн үйлдвэрлэл, мебель тавилга үйлдвэрлэл зэрэг салбарын үйлдвэрлэлийн өсөлт нөлөөлсөн байна.
268. Боловсруулах аж үйлдвэрийн улсын дүнд нийслэлийн боловсруулах салбарын үйлдвэрлэлт 45.0 хувийг эзэлж байна.
269. Нийслэлд 2010 онд оны үнээр 190.1 тэрбум төгрөгийн цахилгаан, дулаан, ус үйлдвэрлэсэн нь өмнөх оныхоос 15.2 хувиар өслөө.
270. 2010 онд улсын хэмжээнд 4312.8 сая.квт.цаг цахилгаан, 8.4 сая гкал дулаан, 61.7 сая метр куб ус түгээсэн бол үүнээс нийслэлийн хэмжээнд 3173.9 сая квт.цаг цахилгаан, 5.1 сая гкал дулаан, 43.2 сая метр куб ус түгээсэн байна.
271. 2005-2010 онд аж үйлдвэрийн гол нэрийн зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэл тухайлбал, сүү, сүүн бүтээгдэхүүн, гурил, өлөн гэдэс, хүнсний давс, архи дарс, цахилгаан эрчим хүч, нүүрс, хайлуур жоншны баяжмал, улаан тоосго, сүлжмэл эдлэл, эсгий, сонин, ном, сэтгүүлийн үйлдвэрлэл 6.9-99.7 хувь өссөн байна.

272. Нэг хүнд ногдох нийслэлийн төсвийн орлогын хэмжээ 2010 онд 144.8 мянган төгрөгт хүрч өмнөх оноос 18.0 хувиар, төсвийн зарлага 91.3 мянган төгрөгт хүрч 61.9 хувиар өссөн байна.
273. Нийслэлийн төсвийн орлого Монгол улсын нийт төсвийн орлогын 45.3 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд орон нутгийн төсвийн зарлагын 34.7 хувийг эзэлж байна.
274. Нийслэл хотын өмч 2010 онд 82.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, бүртгэлийн дүнгээр 659.4 тэрбум төгрөгт хүрээд байна.
275. Нийт хөрөнгийн 16.4 хувийг эргэлтийн хөрөнгө, 83.6 хувийг эргэлтийн бус хөрөнгийн дүн эзэлж байна
276. Нийслэлийн өмчийг байршлаар авч үзвэл, нийт хөрөнгийн 21.4 хувь нь Баянзүрх, 20.5 хувь нь Чингэлтэй, 13.8 хувь нь Сүхбаатар, 13.8 хувь нь Баянгол, 12.6 хувь нь Сонгинохайрхан, 10.1 хувь нь Хан-уул, үлдсэн 7.8 хувь нь Багануур, Багахангай, Налайх дүүргүүдэд тус тус байршиж байна.
277. Нийслэлийн нийгмийн даатгалын байгууллага 2010 онд давхардсан тоогоор 2902.9 мянган хүнд үйлчилж, нийгмийн даатгалын үйлчилгээний хүрээ өмнөх оныхоос 32.7 хувиар буюу 715.2 мянган хүнээр нэмэгдсэн байна.
278. Нийгмийн даатгалын санд хуримтлуулсан нийт орлогын 63.1 хувь нь тэтгэврийн даатгалын санд, 20.8 хувь нь эрүүл мэндийн даатгалын санд, 4.5 хувь нь тэтгэмжийн даатгалын санд, 7.2 хувь нь үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын санд, 4.4 хувь нь ажилгүйдлийн даатгалын санд тус тус төвлөрсөн байна.
279. Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оныхоос 53.3 тэрбум төгрөгөөр буюу 28.9 хувиар нэмэгдсэн байна.
280. 2010 онд нийслэлийн нийгмийн даатгалын байгууллага 1421889 даатгуулагч, иргэдэд 227.1 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, эмчилгээний зардал, эмийн үнийн хөнгөлөлт олгосон нь өмнөх оныхоос 16.5 хувиар буюу 32.2 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.
281. Нийгмийн даатгалын тэтгэврийн сангаас сард дунджаар 116.7 мянган хүнд тэтгэвэр олгосон бөгөөд олгосон тэтгэврийн хэмжээ өссөн дүнгээр 163.4 тэрбум төгрөгт хүрчээ.
282. Нийслэлийн тэтгэвэр авагч нэг хүний сарын дундаж тэтгэврийн хэмжээ 119.7 мянган төгрөг байна.
283. Түүнчлэн нийгмийн даатгалын сангаас нийт 72.3 мянган хүнд тэтгэмж, нөхөн төлбөр олгожээ.
284. Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын 70.6 хувь, үйл ажиллагаа явуулсан ААНБ-ын 65.6 хувь нь нийслэл хотод байршдаг.

285. Нийслэл хотод 2010 онд үйл ажиллагаа явуулахаар 53627 аж ахуйн нэгж, байгууллага бүртгүүлсэн байна.
286. Нийт бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагын 50.1 хувь буюу 26851 нь жилийн турш байнга үйл ажиллагаа явуулжээ.
287. Үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын 21.1 хувь нь Баянгол, 19.8 хувь нь Баянзүрх, 19.0 хувь нь Сүхбаатар, 17.3 хувь нь Чингэлтэй, 14.3 хувь нь Сонгинохайрхан, 6.2 хувь нь Хан-Уул, 1.4 хувь нь Налайх, 0.8 хувь нь Багануур, 0.1 хувь буюу 19 нь Багахангай дүүргийн нутаг дэвсгэрт байрладаг.
288. Эдгээр ААНБ-ын 89.1 хувь буюу 23929 нь 1-ээс 9 ажиллагчидтай бол 4.8 хувь нь 10-19, 3.5 хувь нь 20-49, үлдсэн 2.6 хувь буюу 700 аж ахуй нэгж нь 50-аас дээш тооны ажиллагчидтай байна.
289. Нийслэл хотод бүртгэлтэй ААНБ-ын 2.3 хувь нь төрийн өмчийн, 0.1 хувь нь орон нутгийн өмчийн, 97.6 хувь буюу 52371 ААНБ хувийн эзэмшилд байна.
290. Хувийн өмчийн ААНБ-ын 5.4 хувь нь гадаадтай хамтарсан, 7.0 хувь нь гадаадын иргэний өмчлөлд байна.
291. Нийслэлийн нийт хүн амын 38.2 хувь нь цэвэр усыг төвлөрсөн ус түгээх системээр, 61.8 хувь нь 559 ус түгээх цэг, худаг болон зөөврөөр авч байна.
292. 2010 онд орон сууцны нэг оршин суугч хоногт дунджаар 188.5 литр цэвэр ус, гэр хороололд амьдардаг хүн 4.9 литр цэвэр ус хэрэглэсэн гэж тус тус төлбөрөө төлжээ.
293. Нийслэлийн шуурхай мэдээллийн төвд 2010 онд хотоос иргэд, аж ахуй нэгж, байгууллагад үзүүлж буй үйлчилгээний талаар 3460 санал, гомдлыг хүлээн авсан нь өмнөх жилээс 1242 гомдол буюу 26.4 хувиар буурчээ. Нийт хүлээн авсан санал гомдлын 99.0 хувийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас шийдвэрлэсэн байна.
294. Монгол улсын бөөний болон жижиглэн худалдааны нийт борлуулалт 2010 онд урьдчилсан байдлаар 4918.7 тэрбум төгрөг байсан ба үүнээс 4174.6 тэрбум буюу 84.9 хувь нь нийслэл хотод дангаараа хийгдэж байна.
295. Худалдааны нийт борлуулалтын 79.6 хувийг бөөний, 20.4 хувийг жижиглэн худалдаа эзэлж байна.
296. 2010 онд Улаанбаатар хотод 3519 хүнсний дэлгүүр, 81 бөөний худалдааны төв, 22 зах, 791 түргэн үйлчилгээний цэгүүд жилийн турш үйл ажиллагаа явуулсан байна.
297. Нийслэлд бөөний болон жижиглэнгийн нийт 4174.6 тэрбум төгрөгний худалдаа хийгдсэн нь 2007 оноос 2048.9 тэрбум буюу 96.4 хувь, 2008

оноос 991.4 тэрбум буюу 31.1 хувь, 2009 оноос 1396.4 тэрбум буюу 50.3 хувиар тус тус өссөн байна.

298. 2010 онд Монгол улсын хэмжээнд худалдааны нийт борлуулалт 4918.7 тэрбум төгрөгт хүрсэн ба 84.9 хувь нь Улаанбаатар хотод, үлдсэн 15.1 хувь нь бусад аймгуудад үйл ажиллагаа явуулж байна.
299. Худалдааны салбарын нийт аж ахуйн нэгжийн 10.0 гаруй хувийнх нь жилийн борлуулалтын орлого 50 сая төгрөгнөөс дээш ба эдгээр ААН-ийн орлогын дүн худалдааны нийт борлуулалтын орлогын 90.0 гаруй хувийг эзэлдэг байна.
300. Нийслэлийн худалдааны нийт цэгийн 79 хувь нь хүнсний дэлгүүр, 18 хувь нь түргэн үйлчилгээний цэг, 2 хувь нь бөөний худалдааны төв, үлдсэн 1 хувийг хүнсний болон барааны зах эзэлж байна.
301. Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор нийслэлд тоологдсон нийт өрхийн 9.5 хувь нь нэг, 15.4 хувь нь хоёр, 23.1 хувь нь гурав, 24.2 хувь нь дөрөв, 14.6 хувь нь тав, 7.5 хувь нь зургаа, 3.1 хувь нь долоо, 2.6 хувь нь найм ба түүнээс дээш ам бүлтэй байна.
302. Нийслэлийн нийт өрхийн 29 хувь нь монгол гэрт, 69.7 хувь нь байшин сууцанд, 1.4 хувь нь зориулалтын бус сууцанд, харин 21 өрх бусад төрлийн сууцанд амьдарч байна.
303. Нийслэл хотын 1248 өрх оюутан сурагчдын нийтийн байр, 5130 өрх ажиллагчдын нийтийн байранд, 2946 өрх нийтийн зориулалтын бусад байранд амьдарч байна.
304. Нийслэлд байшинд суудаг өрхийн 51.4 хувь нь орон сууцны байшинд, 0.99 хувь нь бие даасан тохилог сууцанд, 43.1 хувь нь сууцны тусдаа байшинд амьдардаг.
305. Нийслэл хотын суурин хүн амын 10.4 хувь нь 0-4 насны, 6.9 хувь нь 5-9 насны хүн ам байна.
306. Нийслэлийн хүн амын 13.8 хувь нь 20-24 насны хүн ам байна.
307. Нийслэлийн хүн амын 25.2 хувь нь 40 ба түүнээс дээш насны хүн ам байна.
308. Нийслэл хотод 70 ба түүнээс дээш насны 25981 хүн амьдран сууж байна.
309. Нийслэлийн 6 ба түүнээс дээш насны хүн амын 90.5 хувь нь боловсролтой, харин 9.5 хувь нь огт боловсрол эзэмшээгүй байна.
310. Нийслэл хотод 6 ба түүнээс дээш насны бичиг үсэг мэддэггүй 12047 хүн байна. Бичиг үсэг мэддэггүй хүн амын 51.8 хувь нь эрэгтэйчүүд байна.
311. Нийслэл хотод хөгжлийн бэрхшээлтэй 37404 хүн байна. Эдгээр хүмүүсийн 28.3 хувь төрөлхийн бол бусад нь олдмол хөгжлийн бэрхшээлтэй байна.

312. Нийслэл хотын байшинд амьдардаг өрхийн 71.2 хувь нь 1-2 өрөөтэй, 26 хувь нь 3-4 өрөөтэй, үлдсэн хувь нь 5 ба түүнээс дээш өрөөтэй байшинд амьдарч байна.
313. Нийслэл хотын 86 мянган иргэн гадаад улс оронд амьдарч байна. Гадаад амьдарч буй нийслэлийн иргэдийн 27.5 хувь Өмөд Солонгос улсад, 18 хувь нь АНУ-д амьдарч байна.
314. Нийслэлийн байшин болон гэрт амьдардаг нийт өрхийн 1.1 хувь буюу 3202 өрх цахилгааны эх үүсвэргүй байна.
315. Нийслэлийн байшин болон гэрт амьдардаг нийт өрхийн 98.4 хувь нь төвлөрсөн системээс цахилгаан эрчим хүч хэрэглэдэг байна.
316. Нийслэлийн байшин болон гэрт амьдардаг нийт өрхийн 0.2 хувь нь сэргээгдэх эрчим хүчний эх үүсврээс цахилгаан хэрэглэдэг.
317. Нийслэлийн байшин болон гэрт амьдардаг нийт өрхийн 0.3 хувь нь бага оврын цахилгаан үүсгүүрээр цахилгааны хэрэглээгээ хангадаг.
318. Нийслэлийн байшин болон гэрт амьдардаг нийт өрхийн 38.8 хувь нь хүйтний улиралд дулаанаа төвлөрсөн системээс авдаг байна.
319. Нийслэлийн байшин болон гэрт амьдардаг нийт өрхийн 4.7 хувь нь хүйтний улиралд халаалтаа нам даралтын зуухнаас авдаг.
320. Нийслэлийн байшин болон гэрт амьдардаг нийт өрхийн 55.8 хувь хүйтний улиралд ердийн галлагаагаар халаалт авдаг.
321. Нийслэлийн байшин болон гэрт амьдардаг нийт өрхийн 0.4 хувь нь хүйтний улиралд цахилгаан халаагуур хэрэглэдэг.
322. Нийслэлийн байшин болон гэрт амьдардаг нийт өрхийн 52.4 хувь хоол ундаа ихэвчлэн цахилгаан эрчим хүч ашиглан бэлтгэдэг.
323. Нийслэлийн байшин болон гэрт амьдардаг нийт өрхийн 1.8 хувь нь хоол ундаа савласан хий ашиглан бэлтгэдэг.
324. Нийслэлийн байшин болон гэрт амьдардаг нийт өрхийн 9.3 хувь нь хоол ундаа ихэвчлэн мод түлж бэлтгэдэг.
325. Нийслэлийн байшин болон гэрт амьдардаг нийт өрхийн 35.5 хувь нь хоол хүнсээ нүүрс, шахмал түлш түлж бэлтгэдэг.
326. Нийслэлийн байшин болон гэрт амьдардаг нийт өрхийн 0.7 хувь нь хоол хүнсээ аргал хөрзөн түлж бэлтгэдэг.
327. Нийслэлийн байшинд амьдардаг өрхийн 12.4 хувь нь бусдын сууцанд түрээсийн төлбөр төлж амьдардаг.

328. Нийслэлийн байшинд амьдардаг өрхийн 6.6 хувь нь бусдын сууцанд түрээсийн төлбөр төлөхгүй амьдардаг.
329. Нийслэлийн байшинд амьдардаг өрхийн 80.3 хувь нь өөрийн эзэмшлийн сууцанд амьдардаг.
330. Монгол гэрт амьдардаг өрхийн 65.2 хувь нь таван ханатай гэрт амьдардаг.
331. Монгол гэрт амьдардаг өрхийн 28 хувь нь тав хүртэл ханатай гэрт амьдардаг.
332. Монгол гэрт амьдардаг 87.5 мянган өрх нийтдээ 89.3 мянган ширхэг монгол гэртэй.
333. Монгол гэрт амьдардаг 87.5 мянган өрхийн 88.1 хувь нь өөрийн эзэмшлийн гэрт амьдардаг.
334. Монгол гэрт амьдардаг нийт өрхийн 57.5 хувь нь төвлөрсөн системд холбогдоогүй ус түгээх байрнаас цэвэр усаа авдаг.
335. Монгол гэрт амьдардаг нийт өрхийн 35.5 хувь нь төвлөрсөн системд холбогдсон ус түгээх байр, хамгаалагдсан худаг, булаг шандаас болон цэвэршүүлэн савласан усыг хэрэглэдэг.
336. Нийслэлийн нэг иргэн сард 6.4 кг мах, махан бүтээгдэхүүн хэрэглэдэг.
337. Нийслэлийн нэг иргэн сард 5.8 литр сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэж байна.
338. Нийслэлийн нэг иргэн сард 11 кг гурил, гурилан бүтээгдэхүүн хэрэглэж байна.
339. Нийслэлийн нэг иргэн сард 1.7 кг будаа хэрэглэж байна.
340. Нийслэлийн нэг иргэн сард 4.2 кг төмс хэрэглэж байна.
341. Нийслэлийн нэг иргэн сард 2.6 кг хүнсний ногоо хэрэглэж байна.
342. Нийслэлийн нэг иргэн сард 5 ширхэг өндөг хэрэглэж байна.
343. Нийслэл хотод 2010 онд 5.3 мянган тонн төмсийг хураан авсан нь өмнөх жилээс 32 хувиар их байна.
344. Нийслэл хотод 2010 онд 3.0 мянган тонн хүнсний ногоо хураан авсан нь өмнөх жилээс 1.6 дахин их байна.
345. Нийслэлийн хэмжээнд 2011 оны эхний 10 сард 401.0 га талбайгаас 3824.3 тонн төмс, 350.1 га талбайгаас 3409.6 тонн хүнсний ногоо хураан авав.

346. Нийслэлийн хэмжээнд 2011 оны эхний 10 сард 22486.1 тонн өвс хадлан, 354.3 тонн гар тэжээл, 133.3 тонн даршны ургамал бэлтгэсэн байна.
347. Нийслэлд 2011 онд хурааж авсан нийт ургацын 18.8 хувийг аж ахуйн нэгж байгууллага, 81.2 хувийг иргэд хураажээ.
348. Нийслэл хотод өдөрт дунджаар 15 өрх шинэ орон сууцанд нүүн орж байна.
349. Нийслэл хотын худалдааны нэг цэгт 38 хүн ногдож байгаа нь улсын дунджаас 16 хүнээр бага байна.
350. Нийслэл хотод цэвэр ус түгээх 559 байр өдөр бүр үйлчилдэг.
351. Нийслэл хотод 1068 хүний багтаамжтай 190 халуун усны үйлчилгээний газар ажилладаг.
352. Нийслэлд Чингэс хаан нисэх онгоцны буудалд улсын хилээр нэвтрэн өдөрт дунджаар 788 хүн гадагшаа зорчиж, 765 хүн зочилж ирдэг.
353. Нийслэл хотод Чингэс хаан нисэх онгоцны буудлаар дамжин өдөрт дунджаар 101 хүн албан ажлаар гадаад улс руу зорчдог.
354. Нийслэл хотод Чингэс хаан нисэх онгоцны буудлаар дамжин өдөрт дунджаар 60 хүн жуулчлалаар гадаад улс руу зорчдог.
355. Нийслэл хотод 2010 онд “Тогтвортой амьжиргаа –II” төслийн хүрээнд 517.8 сая төгрөгийн 46 төслийг хотын боловсролын салбарын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор хэрэгжүүлсэн байна.
356. Нийслэл хотод 2010 онд “Тогтвортой амьжиргаа –II” төслийн хүрээнд 104 сая төгрөгийн 11 төслийг хотын эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор хэрэгжүүлсэн байна.
357. Нийслэл хотод 2010 онд “Тогтвортой амьжиргаа –II” төслийн хүрээнд 544.8 сая төгрөгийн 45 төслийг хотын дэд бүтцийг сайжруулах зорилгоор хэрэгжүүлсэн байна.
358. Нийслэл хотод 2010 онд “Тогтвортой амьжиргаа –II” төслийн хүрээнд бичил санхүүгийн хөгжлийн сангаас нийт 272 хүнд 746.7 сая төгрөгийн зээлийг олгосон байна.
359. Улаанбаатар хот далайн төвшнөөс дээш 1350 метр өндөрт Номхон далайгаас 1600 орчим км алсад, Дэлхийн экватороос хойш 5310 км, хойд туйлаас урагш 4690 км зайтай буюу дэлхийн хойд өргөрөгийн  $47^{\circ}55^I$ , зүүн уртрагийн  $106^{\circ}55^I$  –ын солбицолд, дэлхийн цагийн 7 дугаар бүсэд Лондон хотоос 7 цаг 08 минутын зөрөөтэй оршиж байна.
360. Улаанбаатар хот урдуураа Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг, баруунаараа мөн аймгийн Алтанбулаг, Аргалант, Баянцогт, баруун хойгуураа мөн аймгийн Батсүмбэр, зүүн хойгуур, зүүгээрээ мөн аймгийн Батсүмбэр,

Эрдэнэ сумтай хиллэн нийт 470444 га талбай бүхий нутаг дэвсгэрийг эзэлдэг.

361. Нийслэлийн нутаг дэвсгэрийн хамгийн өмнө захын цэг нь Төв аймгийн Сэргэлэн сумтай хиллэж байгаа хойд өргөрөгийн  $47^{\circ} 37^{\text{I}} 30^{\text{II}}$ , зүүн уртрагийн  $107^{\circ} 18^{\text{I}} 54^{\text{II}}$  –ын солбицолд, баруун захын цэг нь Төв аймгийн Баянчандмань, Батсүмбэр сумтай хиллэж байгаа зүүн уртрагийн  $107^{\circ} 23^{\text{I}} 12^{\text{II}}$ , хойд өргөрөгийн  $48^{\circ} 16^{\text{I}} 42^{\text{II}}$ –ын солбицолд, хойд захын цэг нь Төв аймгийн Батсүмбэр сумтай хиллэж байгаа хойд өргөрөгийн  $48^{\circ} 16^{\text{I}} 00^{\text{II}}$ , зүүн уртрагийн  $106^{\circ} 27^{\text{I}}$  –ын солбицолд, зүүн захын цэг нь Төв аймгийн Эрдэнэ сумтай хиллэж байгаа зүүн уртрагийн  $107^{\circ} 37^{\text{I}} 24^{\text{II}}$ , хойд өргөрөгийн  $47^{\circ} 53^{\text{I}}$  –ын солбицолд оршино.
362. Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайн баруун урд захад Монгол улсын автозамын сүлжээний эхлэх 00 цэгийн тэмдэг багана оршдог.
363. Улаанбаатар хотын нутгийн хүйс буюу төв цэгийг дээр дурдсан захын цэгүүдээр хөөж бодвол хойд өргөрөгийн  $47^{\circ} 56^{\text{I}} 45^{\text{II}}$ , зүүн уртрагийн  $107^{\circ} 00^{\text{I}} 18^{\text{II}}$  –ын солбицолд буюу Шархадны хясаанаас баруун хойш 1.8 км зайтай уулын нэг оройн зүүн хажууд оршиж байна.
364. Улаанбаатар их хотын төв цэг хүйсийг Сүхбаатарын талбайд хойд өргөрөгийн  $47^{\circ} 55^{\text{I}} 07^{\text{II}}$ , зүүн уртрагийн  $106^{\circ} 55^{\text{I}} 04^{\text{II}}$  –ын солбицолд далайн төвшнөөс 1300 метр өндөрт тавьсан Төв цэгийн тэмдгээр тооцож болох юм.
365. Улаанбаатар хотын өмнүүр орших Богдхан уул нь зүүнээс баруун тийш чиглэсэн 40 орчим км үргэлжилсэн нуруу юм. Богд Хан Уулын хамгийн өндөр оргил нь далайн түвшнээс дээш 2268 метр өндөрт өргөгдсөн Цэцээ Гүн, 2256 метр өндөрт орших Түшээ гүн хэмээх оргилууд болно.
366. Улаанбаатар хотын уур амьсгал нь манай орны уур амьсгалын эх газарлаг шинж чанарыг бүрэн илэрхийлэх эрс тэс шинжтэй. Сэрүүн бүсийн эх газрын уур амьсгалын эрс тэс эх газарлаг шинж чанарыг илэрхийлсэн тодорхой ялгарсан жилийн дөрвөн улиралтай. Өвөл нь хүйтэн, үнэмлэхүй бага температур нь  $-49^{\circ}\text{C}$  хүрдэг, үнэмлэхүй их температур нь  $38.6^{\circ}\text{C}$ , үнэмлэхүй их бага температурын агууриг нь  $87.6^{\circ}\text{C}$  болдог энэ эрс тэс ялгаатай бөгөөд ийм их зөрөө дэлхийн аль ч улсын нийслэлд гардаггүй байх.
367. Нийслэлийн жилийн дундаж температур нь  $-3^{\circ}\text{C}$ , хамгийн хүйтэн 1-р сарын температур нь  $-26^{\circ}\text{C}$  байх бөгөөд  $-30^{\circ}\text{C}$ -аас бууж хүйтрэх өдрийн тоо жилд 40 орчим байна. Улаанбаатарт хүйтрэлтгүй үргэлжлэх хугацаа 5-р сарын 29-ны орчмоос 9-р сарын 2 орчим хүртэл буюу 90 хоног байна. Энэ хугацаанд агаарын температур  $0^{\circ}\text{C}$ -аас доош буухгүй. Жилийн хамгийн дулаан сар нь 7-р сар бөгөөд дундаж температур нь  $17^{\circ}\text{C}$ , хамгийн халуун болсон нь  $38^{\circ}\text{C}$  хүрсэн. Зундаа  $30^{\circ}\text{C}$ -аас давж халуун болох өдрийн тоо 10 орчим, ган болох магадлал 30 орчим хувь байдаг.

368. Улаанбаатар хот нь дэлхийн хамгийн цэлмэг хөх тэнгэрт хотуудын нэг бөгөөд жилдээ 250-иад хоног цэлмэг байдаг.
369. Улаанбаатар хот манай орны салхи багатай газрын тоонд орно. Жилдээ салхигүй өдөр 100 орчим байх бөгөөд салхины хурд 4-6 м\с, баруун хойд зүгийн салхи голлоно. Өвөл салхи багатай, хавар нь салхи ихтэй.
370. Улаанбаатарт жилд дунджаар 233 мм тунадас унаж, ууршилт нь 648 мм болдог. Чийгшлийн байдал 0.36 байдаг. Агаарын харьцангуй чийг 1-р сард 70 орчим хувь, 7-р сард 60 орчим хувь байдаг.
371. Улаанбаатарын орчмын голуудын ус химийн найрлагын хувьд гидрокарбонатлаг ангилалд багтах бөгөөд голын сүлжээний нягтшилт 0.01-0.05 км\км<sup>2</sup> байна.